

2019 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДРИЙН
ШУУРХАЙ ХУРЛААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

2019 оны 4-р сарын 15

№ 10

Дархан-Уул аймаг

№	Өгөгдсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн	Хэрэгжилт
1	Санхүү, төрийн сангийн хэлтэс орлого биелүүлэх асуудлаар зөвлөлийн хуралд асуудал оруулах	СТСХ, ТА	2018 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн Засаг даргын зөвлөлийн хуралд орлого биелүүлэх төлөвлөгөөг танилцуулсан. Удирдлагуудаас өгсөн чиглэлийн дагуу хяналт шалгалтын ажлаар явахаар төлөвлөгөө гарган ажиллаж байна.
2	СӨХ-ийн үйл ажиллагааны тайланг зөвлөлийн хуралд оруулах	ЗАА	2018 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулсан.
3	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын ажлыг эрчимжүүлэх	ХОХБТХ	<p>Хонгор сумын “Сургуулийн дотуур байрны хүүхдийн ор шинэчлэх” ажил 50 хувийн гүйцэтгэлтэй тул 12,500,000.0 /Арван хоёр сая таван зуун мянган/ төгрөгийн санхүүжилтийг “Үсхий улиас” ХХК-д олгосон.</p> <p>Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас:</p> <p>Аймгийн Засаг даргын Тамгын газарт техник хэрэгсэл нийлүүлэх ажил /багц 2, 3/ 80 хувийн гүйцэтгэлтэй тул 3,360,000.0 /Гурван сая гурван зуун жаран мянган/ төгрөгийн санхүүжилтийг иргэн Т.Мөнхжаргалд байгууллагуудын албан хэрэгцээнд бага оврын ачааны машин нийлүүлэх ажил 100 хувийн гүйцэтгэлтэй тул 19,000,000.0 /Арван есөн сая/ төгрөгийн санхүүжилтийг иргэн Д.Энхтүвшинд Аймгийн Засаг даргын Тамгын газарт техник хэрэгсэл нийлүүлэх ажил 100 хувийн гүйцэтгэлтэй тул 15,378,000.0 /Арван таван сая гурван зуун далан найман мянган/ төгрөгийн санхүүжилтийг “Монтех Дистрибьюшн” ХХК-д тус тус олгосон.</p> <p>Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 100190052400 тоот данснаас:</p> <p>Дархан сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 100190152400 тоот дансанд 45,000,000.0 /Дөчин таван сая/ төгрөгийн санхүүжилтийг, Хонгор сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 100190252400 тоот дансанд 50,000,000.0 /Тавин сая/ төгрөгийн санхүүжилтийг,</p>

			<p>Шарын гол сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 100190452400 тоот дансанд 40,000,000.0 /Дөчин сая/ төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон.</p>
4	<p>Ажил эрчимжүүлэх тухай үүрэг чиглэлийн дагуу уул уурхай олборлолтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, ААНэгжүүдийн үйл ажиллагаанд аймгийн ЗДТГ-ын ХОХБТХэлтэс, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газрын хамтарсан хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах</p>	<p>ХОХБТХ</p>	<p>Дархан-Уул аймгийн Цагдаагийн газрын Шарын гол сумын Цагдаагийн хэлтсийн байранд хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх байнгын пост 2019.04.05-ны өдөр Шарын гол сумын Санжинт багийн зэвсэгийн агуулахын дэргэд үйл ажиллагаагаа эхлүүлсэн. 2 дахь постыг 2019.04.11-ны өдөр Хонгор сумын Хүйтний голын Өвгөн толгойн ард байгууллаа.</p> <p>Хяналт шалгалтаар Шарын гол сумын, Санжинт, Хавчуу, Бурхант, Хуурай, Цагаан хөтөл, Шарын хөндий, Хонгор сумын Булагт, Хуурай, Бугтын даваа, Хүйтний голын Цэхэр уулын дэргэдэх ам, Урд хүйтний ам /Эрэлийн ам/, Хүйтний голын эх Бичигт хад хэсэг зэрэг газрууд хамрагдсан. Хяналт шалгалтаар Буянтийн хөндий ХХК, Барилга орд ХХК, Шингчан ХХК, Хааны харгуй ХХК, Рич монгол ХХК, Гуравт ХХК, Морьт хангай ХХК зэрэг компануудийн лицензийн талбай, Хайрханы эвсэг ардууд бичил уурхайн нөхөрлөл, Баялаг хайрханы өв нөхөрлөлүүдийн тусгай хэрэгцээнд авсан газруудад хяналт шалгалтын ажлыг явуулахад Хайрханы эвсэг ардууд нөхөрлөл нь зохих зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаагаа явуулж нөхөрлөлийн гишүүд нь зөвшөөрлөөр олгогдсон Шарын гол сумын Цагаан Хөтөл дэх урсацгүй нуурандаа алтаа угааж байсан. Хүйтний голд байрлах Барилга орд ХХК-ний 10 ажилтан засварын ажлаа хийхээр ирсэн байлаа.</p> <p>Замын бартаа саад ихтэй, зарим газар, даваануудаар авто машин давах боломжгүй байгаатай холбоотой ААНБ болон Нөхөрлөлүүдийн үйл ажиллагаа эхлээгүй байна.</p>

ХЯНАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА
НЭГТГЭСЭН:

П.БАЯРСАЙХАН

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Ц.БОЛОРТУУЛ